



# СОЁМБО

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ!

# МЭДЭЭ

151 /151/

2021.10.06

## "ТЭМҮҮЖИН ӨРЛӨГ" СУРГУУЛЬ НИЙСЛЭЛИЙН ТЭРГҮҮНИЙ СУРГУУЛЬ БОЛЛО



Батлан хамгаалах төрийн захиргааны төв байгууллага үүсэн байгуулагдсаны 110, Монгол Улсын орчин цагийн боловсрол, шинжлэх ухааны

салбар үүсэж хөгжсөний 100 жилийн ой, Дэлхийн болон Монголын багш нарын өдөр, Үндэсний Батлан Хамгаалахын Их сургуулийн 100 жилийн ой тохиож

байгаа түүхэн цаг үед "НИЙСЛЭЛИЙН ТЭРГҮҮНИЙ СУРГУУЛЬ"-иар шалгарсан "Тэмүүжин Өрлөг" сургуулийн эрдмийн хамт олонд халуун баяр хүргэе.

### Түүхэнд энэ өдөр

**1997 он:**  
ЗХЖШ-д Хяналт, шинжилгээ үнэлгээний газар байгуулагдав.

**2010 он:**  
Афганистанд "Ми-17" нисдэг тэрэгний сургалтын зургаан хүний бүрэлдэхүүнтэй засвар үйлчилгээний бүлгийн анхны ээлж үүрэг гүйцэтгэхээр эх орноосоо мордов.

### ЦАГ АГААР

УЛААНБААТАР	
ӨДӨР	ШӨНӨ
☀️ 11	☁️ -2
ӨМНӨД СУДАН	
ӨДӨР	ШӨНӨ
☀️ 32	☁️ 21

### ВАЛЮТЫН ХАНШ

ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD 🇺🇸	2,844.00	2,855.00
EUR 🇪🇺	3,274,0	3,339,0
CNY 🇨🇳	440,00	444,20
RUB 🇷🇺	38,70	40,40
JPY 🇯🇵	25,34	25,92
KRW 🇰🇷	2,32	2,44

### ЗУРХАЙ

2021.10.06 ЛХАГВА ГАРАГ /БИЛГИЙН ТООЛЛЫН 30/

**НАМРЫН ДУНД УЛААГЧИН ТАХИА САРЫН НАЙМАН ЦАГААН УЛААГЧИН ГАХАЙ ӨДӨР**

**Үс засуулбал:**  
Эрлэг лугаа учирна  
Наран ургах, шинжих:  
06.58-18.22  
Барилдлага:  
Үл зохилдох  
Шүтэн барилдлага:  
Төрөн түгэхүй  
Суудал:  
Хий

Аргын тооллын 10 сарын 6, Буд гараг. Билгийн тооллын 30, Тугчин одтой, улаагчин гахай өдөр. Өдрийн наран 6 цаг 58 минутад мандан, 18 цаг 22 минутад жаргана. Тухайн өдөр хонь, туулай жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба могой, морь жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр архи уух, тамхи татах, сэтгэл муутантай нөхөрлөх зэргийг цээрлэх хэрэгтэй ба сан тавиулах, угаал үйлдэх, нялхсын хурим хийх, хийморийн дарцаг хатаахад сайн. Газар ухах, худаг гаргах, сэтгэлд сэтгэй газар очиход муу. Өдрийн сайн цаг нь үхэр, луу, морь, хонь, нохой, гахай болой. Хол газар яваар одогсод урагш мөрөө гаргавал зохистой. Үс шинээр үрээлгэх буюу засуулахад тохиромжгүй.

## “ТЭРБУМ МОД” ҮНДЭСНИЙ ХӨДӨЛГӨӨНД БАТЛАН ХАМГААЛАХ САЛБАР НЭГДЛЭЭ

Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний ерөнхий командлагч Ухнаагийн Хүрэлсүх НҮБ-ын Ерөнхий Ассамблейн хуралд үг хэлэхдээ Монгол Улс нэг тэрбум мод тарих төлөвлөгөөтэй буйгаа уламжилсан. Тус ажлын хүрээнд “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн өрнөөд байгаа юм. Энэхүү хөдөлгөөнийг батлан хамгаалах салбар, Зэвсэгт хүчний алба хаагчид манлайлан оролцохоор салбарын хэмжээнд нийт есөн байрлалд мод үржүүлгийн газрыг үе шаттайгаар байгуулахаар төлөвлөсний нэг нь өнөөдөр нээлтээ хийлээ. Мод үржүүлгийн төсөл амжилттай хэрэгжсэнээр 33 га газарт 3,118,000 тооны мод тарих юм. Мөн таван жилийн дараа гэхэд өнөөдөр эхлүүлж буй мод үржүүлгийн ажлаасаа мөнгө олж санхүүжилт босгох боломж бүрдэнэ гэдгийг Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр хэллээ.

Цаашид батлан хамгаалах салбараас улсын хэмжээнд мод үржүүлгийн 10 газар байгуулж 2030 он хүртэл 22 сая мод тарихаар төлөвлөжээ. Мөн Зэвсэгт хүчний ангиудад экологийн мэргэжилтний орон тоо бий болгож тарьсан модоо арчлан хамгаалах нь чухал гэж салбарын удирдлагууд хэлж байна. Энэ ажлын эхлэл болгож 10 дугаар сарын 7-ны өдрөөс Таван толгой Зүүнбаян чиглэлийн 416,1 км төмөр зам дагуу мод тарих ажлыг эхлүүлэх юм.



### МОНГОЛ УЛС ДАХЬ КОРОНАВИРУСИЙН МЭДЭЭ

НИЙТ БҮРТГЭГДСЭН <b>308.329</b> +2225	ЭДГЭРСЭН <b>353.086</b> +6239	НАС БАРСАН <b>1274</b> +14
--	----------------------------------	-------------------------------

### ЦЭРГИЙН ТӨВ ЭМНЭЛЭГ

НИЙТ БАТЛАГДСАН <b>5396</b> +94	ХЭВТЭН ЭМЧЛҮҮЛЖ БУЙ <b>193</b>	ЭДГЭРСЭН <b>5097</b>
------------------------------------	-----------------------------------	-------------------------

**КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД**

<b>Тохиолдол</b>
Нийт: 236,130,997
<b>Эдгэрсэн</b>
Нийт: 213,179,853
<b>Нас барсан</b>
Нийт: 4,822,154

# АВТО БОЛОН ХУЯГТ ТЕХНИКҮҮДИЙГ ХҮРГҮҮЛНЭ

Бүгд Найрамдах Өмнөд Судан Улсад явагдаж байгаа НҮБ-ын Энхийг сахиулах "UNMISS" ажиллагаанд үүрэг гүйцэтгэж байгаа Монгол Улсын Зэвсэгт хүчний мотобуудлагын батальоны хэрэгцээнд ашиглагдах авто болон хуягт техникуудийг ажиллагааны газар оронд тээвэрлэн хүргүүлэхээр гэрээт Олон улсын тээвэр зуучлалын компанид хүлээн өгөх ажлыг ЗХЖШ-ын даргын тушаалаар томилогдсон ажлын хэсэг зохион байгуулж байна.

Авто болон хуягт техникуудийг хүлээлцэх ажилд ЗХЖШ-ын Материал техникийн газрын Техникийн хэлтсийн ахлах мэргэжилтэн, хурандаа Б.Энхболд, Зэвсэгт хүчний 345 дугаар бригадын авто, хуягт техникийн төлөвлөлт, хангалтын ахлах офицер, хошууч Б.Мөнхтуул, тус улсад үүрэг гүйцэтгэх Зэвсэгт хүчний 11 дүгээр ээлжийн мотобуудлагын батальоны захирагч, хурандаа О.Заяат нар оролцлоо.

Эдгээр авто болон хуягт техникуудийг "Конфрейт-Агент" ХХК-ийн агуулахад байрлуулан нэг бүрчлэн хүлээлцүүлэх ажил үргэлжилж байна. Энэхүү хариуцлагатай ажлыг Зэвсэгт хүчний 11 дүгээр ээлжийн мотобуудлагын батальоны тээврийн салаанаас томилогдсон бүрэлдэхүүн ахмад Г.Мөнх-Учралын удирдлагад хөдөлмөр хамгаалал, аюулгүй байдал, эрүүл ахуй, халдвар, хамгааллын дэглэмийг чанд сахин гүйцэтгэж байна.



## АХЛАГЧ НАРТАЙ МЭРГЭЖИЛ, УР ЧАДВАР ЭЗЭМШҮҮЛЭХ СУРГАЛТЫГ ЯВУУЛЖ БАЙНА



ЦДБЭЧ

### ЦЭРГИЙН ЧУУЛГЫНХАН III УЛИРАЛД ХИЙЖ ГҮЙЦЭТГЭСЭН АЖЛАА ДҮГНЭЛЭЭ

ЦДБЭЧ-ын хамт олон 2021 оны III улиралд хийж гүйцэтгэсэн ажлаа дүгнэн хэлэлцэж, тайлангийн хурлаа зохион байгууллаа. Тайлант хугацаанд чуулгын хамт олон Ардын хувьсгалын 100 жилийн ойд зориулсан цахим контентод оролцсоны зэрэгцээ олон улсын хэрийн сургуульд оролцож буй цэрэг дайчдад зориулсан тоглолт арга хэмжээ, нээлт, хаалтын ажиллагаа, залуусыг хөдөлмөрт бэлтгэх "Оролцоо" төсөлд хамрагдаж буй иргэдэд зориулсан төлөвлөгөөт тоглолтуудыг амжилттай зохион байгуулан, 2021-2022 оны өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах зорилгоор аж ахуй, тохижилт үйлчилгээний ажлуудыг шат дараатайгаар хийж гүйцэтгэсэн байна. Мөн төрийн албан хаагчийн ёс зүй, хууль эрх зүй, сахилга хариуцлагыг дээшлүүлэх чиглэлээр байгууллагын цэвэрлэгээний өдөр зэрэг аянуудад идэвхтэй хамрагдсан сарууд байлаа. Сарын ажлаа дүгнэж хэлэлцсэний дараа "Цэргийн тангараг" давтах хүндэтгэлийн ажиллагааг зохион байгуулж, "Сарын ажлын дүн"-г чуулгын даргын тушаалаар баталгаажууллаа.



Гадаадын цэргийн мэдээ

### АМЕРИКТ 1 БӨМБӨГДӨГЧ ОНГОЦООР 1 ӨДӨРТ 900 МЯНГАН МОДНЫ ҮРСЭЛГЭЭГ ЦӨЛД СУУЛГАЖ, ОЙЖУУЛЖ БАЙНА.

Зэвсэгт хүчний Жанжин штаб болон Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Мэргэжлийн боловсрол, сургалтын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын хамтын ажиллагааны хүрээнд Нийслэлийн Баянзүрх дүүргийн Барилга, технологийн политехник коллежтой хамтран Зэвсэгт хүчний нэгтгэл, ангиудын няравын албан тушаалд ажиллаж байгаа ахлагч нарт мэргэжил, ур чадвар эзэмшүүлэх сургалтыг 2021 оны 9 дүгээр сарын 27-ны өдрөөс зохион байгуулж байна. Энэхүү сургалтад Зэвсэгт хүчний 15 нэгтгэл, ангийн 30 ахлагч хамрагдаж байгаа бөгөөд сургалтыг мэргэжлийн суурь болон мэргэшүүлэх

хэсэг гэсэн үндсэн 2 үе шаттайгаар явуулж байна. Суралцагчид эд хариуцагчийн дүрэм, хөрөнгө ба бүртгэлийг судлах, анхан шатны баримт түүнийг судлах, тайлан тооцоог "excel" программд оруулах, барааны гарал үүсэл болон харилцааны ур чадварт суралцах чадамжуудыг 5 сарын хугацаанд эзэмшиж төгсөх юм.

Түүнчлэн ҮБХИС-ийн харьяа Батлан хамгаалахын удирдлагын академи, Ахлагчийн сургуулийн материаллаг баазыг түшиглэн нэгтгэл, ангийн ахлагчийн дамжаанд 27, ротын ахлагчийн дамжаанд 50 цэргийн алба хаагчийг элсүүлэн сургалтыг зохион байгуулж байна.

Дэлхийн 70 гаруй орны армид нийт 2500 ийм бөмбөгдөгч байгаагаас Америкт 200 гаруй байгаа бөгөөд шинэ албандаа гарчээ. Америк даяар цөлжилтийн аюул нөмөрсөн. Цөлжилтийг зогсоохын тулд хүн хүрч чадахгүй эзгүй хээр, цөлийг ойжуулах шаардлагатай ч хүн хүч, хөрөнгө мөнгөний ихээхэн зардал гардаг.

Ийм хүндрэлтэй тулаад байгаа Массачусетс мужийн захиргаанд "Lockheed Martin Aerospace" компани хуучин бөмбөгдөгч онгоцыг ашиглах санал тавьсаныг хүлээн авчээ. "С-130" нь агаараас минажүүлэх зориулалттай бөмбөгдөгч агаад маш нарийн оновчтойгоор миныг хаядаг.

Мужийн захиргаанаас хийсэн судалгаагаар хүн хүрэхэд хэцүү хээр тал, цөлийг байлдааны онгоцоор бөмбөгдөж үрслүүр суулгах нь ойжуулах компанийг хөлсөлсөнөөс 2-3 дахин хямд тусах тооцоо гарчээ. Нэг бөмбөгдөгч нь мөн өдөрт маш том талбайд шинэхэн үрслүүртэй 900 мянга хүртэлх ногоон "мина" хаях чадалтай аж. Үрслүүртэй ногоон "мина"-ыг нарийн боловсруулж хийжээ. Газарт гүн шигдэх конус хэлбэрт үзүүртэй "мина" болгонд нэг үрслүүр хийнэ. Хөрсөнд гүн шигдсэн даруйд "мина"-ын гэр задарч үрслүүрийг суулгадаг аж. Өдгөө хуучирсан бөмбөгдөгчид мужийн хүн хүрч чадахгүй хээр тал, цөлийг бөмбөгдөж байна. Мөн Канад, Австрали болон Египетээс захиалга авчээ.

